

Баяндэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газрын
2021 оны 11 дүгээр сарын мэдээ

2021.11.25

Нэг: Удирдлага, зохион байгуулалтын талаар:

а/ Сумын ИТХ-ын чиглэлээр: йАймгийн ИТХ-ын ажлын албанаас хяналт шинжилгээ үнэлгээний шалгалт хийж ажлын зөвлөл чиглэл өгсөн. Мөн Аймгийн прокурорын орлогч Чинбат, Прокурор Роза нарын бүрэлдхүүнтэй ажлын хэсэг суманд ажиллаа. Сумын ГХУССЗийн хурлыг 2 удаа хуралдуулсан.

Монгол улсын их хурлын дарга Г.Занданшатарын нэрэмжит шатар сонирхогчдын сумын шатрын аварга шалгаруулах насанд хүрэгчдийн эрэгтэй, эмэгтэй ангиллаар явуулж аваргуудыг шалгаруулж шалгарсан эрэгтэй, эмэгтэй шатарчидад аймгийн аварга шалгаруулах тэмцээний эрх олголоо.

б/ Тамгын газрын төрийн удирдлагын ажлын чиглэлээр:

Тухайн сард дээд газраас 28 албан бичиг ирсний хариутай 9 албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

Аймгийн ХШҮДАХэлтсээс сумын 2021 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийж арга зүйн зөвлөгөөг өгч зөвлөн туслах үйлчилгээг үзүүллээ.

Хоёр: Төсөв санхүүгийн чиглэлээр: 2021 оны орлогын төлөвлөгөөг нийт дүнгээрээ Шилэн дансанд тухай бүр болон сар, улирлаар тавигдах мэдээллийг бүрэн тавьж илгээлээ.

Орон нутгийн төсвийн байгууллагын санхүүгийн дэмжлэг, Тусгай шилжүүлгийн байгууллагын санхүүжилтыг хуваарийн дагуу бүрэн олгогдсон. Аймгаас авах санхүүгийн дэмжлэг 399,9, төсвийн орлого 540,8 сая төгрөгийн орлого төвлөрсөн. Байгууллагын өр авлага, төсвийн гүйцэтгэлийн мэдээг хүлээн авч ЗГУСХС бүрэн мэдээлсэн.

Статистикийн байгууллагад хүргүүлэх сар улирлын мэдээ тайланг хугацаанд нь гаргаж, цахим санд шивсэн. ААН, ХХЭрхлэгч нарын 2021 оны улсын тооллогод аж ахуйн нэгж 52, хувиараа хөдөлмөр эрхлэгч 35 иргэн тооллогод бүрэн хамрагдсан. ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтын дансаар ундны усны хөнгөлөлт олгоод байна. Засаг даргын тамгын газрын ажлын өрөө тасалгааны хаяг, байгууллагын мэдээлэлийн ил тодын самбар, тамгын газрын гадна хаалгын захилга өгч шинэчлэсэн. Нийт зардал 720000 төгрөг.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд: Хавар, намрын хуурайшилтын үед Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйл, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйл, Ойн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэн ой, хээрийн гал түймрийн цагийн байдлын тухай мэдээг Онцгой байдлын байгууллагад тухай бүр мэдээлж ажиллах албан даалгаврын дагуу Сумын төвд оршин сууж байгаа 314-н өрх, ковид цар тахлын үед шатах тослох материал авч 2 –р багийн хөдөөний 198 өрх жолооч нарт анхааруулах санамжийг өгч нийт 438 иргэнээс гарын үсгийн баталгааг авч ажилласан.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд: ЕБСургууль: БСУГ-ын мэргэжилтэн нар ЕБСургуулийн үйл ажиллагаа, багш нарын хөтөлбөр төлөвлөгөөтэй танилцан чиглэл, зөвлөмж, зөвлөгөөг өглөө. БСУГ-ын дарга Байгальмаа “Мэргэжлийн чиг баримжаа олгох” сургалтыг ахлах ангийн

сурагчидад зохион явууллаа. Мөн “Хүүхэд хамгаалал” сэдвээр ЕБС-ын нийт багш, ажилчдад сургалтыг зохион явууллаа.

ГБХЗ-ын газрын мэргэжилтнүүд “Хүүхэд хамгаалал” сэдвээр ахлах ангийн сурагчдад мэдээллийг хүргэсэн.

“Хувь хүний ур чадвар олгох энтрепернешип” сургалтын 1-р ээлжийн анги амжилттай төгсөн төгсөлтийн арга хэмжээг зохион байгууллаа. “Хувь хүний ур чадвар олгох энтрепернешип” төслийн хариуцсан мэргэжилтэн Марал, Мониторинг Лхагвасүрэн нар Ерөнхий боловсролын сургууль дээр ирж төслийн үйл явцтай танилцлаа.

Хүүхдийн цэцэрлэг: Орчин цагийн боловсролын байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан “Эрдэм сурахын ач тус” сэдвээр 7 бүлэгт сургалт үйл ажиллагааг зохион байгуулж энэ сард нийт 14 нээлттэй хичээл зохион байгуулсан. ЕБС-ийн Багын багш цэцэрлэгийн багш нарын хамтын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор “Зочин багш” үйл ажиллагааг зохион байгууллаа. Уг үйл ажиллагаанд сургалтын менежер 5 багшийн хамт хүрэлцэн ирж оролцсон. Үүний үр дүнд сургуульд бэлтгэгдэн орж байгаа хүүхдийн чадвар ямар байгаа цаашид юун дээр анхаарах талаар мэдэн төлөвлөгөөндөө тусган ажиллаа.

Цэцэрлэгийн ёс зүйн зөвлөлийн баг бүрэлдэхүүнээс багш ажилчдадаа А-243 журмын талаар сургалт зохион байгуулж 25 хүн хамрагдлаа. “Айдасгүй, аюулгүй, архигүй ирээдүйг бий болгоход эмэгтэйчүүдийн оролцоо” сургалтанд цахимаар 15 багш ажилчид хамрагдсан.

Хүүхдийн хоолны амт чанар, ашиг тус аюулгүй байдлыг эцэг эхчүүдэд таниулах зорилгоор цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн багаас “Хоолны өдөрлөг”-ийг зохион байгуулж нийт 21 эцэг эхийг хамрууллаа.

Эрүүл мэндийн төв: Тухайн сард нийт үзлэгт 294, идэвхтэй хяналт – 24 урьдчилан сэргийлэх үзлэг – 124. Ковид-19 халдварын түргэвчилсэн шинжилгээг 418 иргэнд хийсэн. Голомтын эцсийн ариутгал 5580 м/кв талбайд хийсэн. Халдвараас урьдчилан сэргийлэх Хятад улсын Синофарм үйлдвэрийн Вероцелл, АНУ-ын фэйзер вакцины 3 дахь тунг 18-с дээш насны 3257 иргэнээс 1442 иргэнийг хамруулж 40,3%-тай байна.

Соёлын төв:

Тав: Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн хүрээнд:

Байгаль орчин: ОНХС-ийн 4 200 000 төгрөгийн өртгөөр Сумын төвийн 2 усан сангийн нөөцийн савыг стандарт /ISO14001, ISO9001/-ын болгон шинэчлэлээ.

Ковш үйл ажиллагаандаа ашиглагдаж эхэлсэнээр тэлсэн хог хаягдлыг нийт 4 удаа, сум тойрсон эвдэрсэн машины 12 сэгийг нэгдсэн хогийн цэгт зайлуулсан. Холбогдох шатахууны зардалд 1 553 000 төгрөгийг зарцуулсан.

Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2021 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 17-03-018/129 тоот албан шаардлагын дагуу “Ундны усны аюулгүй байдалд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг сумын Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/144 дүгээр захирамжаар баталлаа.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: Дэлгэр, Дөхөм багийн 13-н суурийн 2137 ямаанд үзлэг ангилалт хийж, ээмэглэн бүртгэлжүүлэх, ашиг шимийн гарц тогтоох, намрын амьдын жин тодорхойлох ажлыг хийж гүйцэтгэсэн. Ангилалтанд хамрагдсан цөм

сүргийн 13 суурийн 2129 толгой хээлтэгч, хээлтүүлэгчийн бүртгэлийг удам зүйн программд шивж аймгийн ХХААГ-т хүргүүлсэн.

Мал эмнэлэгийн чиглэлээр: Аймгийн засаг даргын А/444 тоот, Сумын засаг даргын 2021 оны 09 сарын 21-ний өдрийн А/115 тоот “Мал сүрэгт шинжилгээ хийх тухай” захирамжийн дагуу 2991 хээлтүүлэгчээс бруцеллёз өвчний дээжийг авч шинжилгээнд хүргүүлсэн.

Сүхбаатар аймгийн мэргэжлийн хяналтын газрын хяналт шалгалтын удирдамжийн дагуу мал эмнэлгийн тасагт хяналт шалгалт хийгдэж 22,3 хувьтай үнэлэгдэж бага эрсдэлтэйгээр дүгнэгдсэн. Мөн хувийн хэвшлээс “Агарданшүг ХХК”, “Залаат шар ХХК”, “Энх мэндийн элч ХХК”, “Шинэ-оточ ХХК”, бага эрсдэлтэй гарсан ба “Сүргийн оточ” БГБХН –д ажил сайжруулах албан шаардлага мэргэжлийн хяналтын газраас хүргүүлсэн.

Сүхбаатар аймгийн мал эмнэлгийн газраас Галзуу-72000 тун, Боом-13л Дуут-17л вакцинуудыг татан авч таван аж ахуй нэгжүүдэд хувиарлан цахим системд төлөвлөгөөг оруулан, галзуу бод-6551, бог-65099, боом бод-1558, бог-22654, дуут үхэр-1640, тугал-2785 малыг вакцинжуулан холбогдох материалуудыг аймгийн мал эмнэлгийн газарт хүргүүлж ажилласан.

Нэгтгэсэн: ХЭЗХ-мэргэжилтэн

Ж.Долгорсүрэн